



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 285

Улаанбаатар хот


Харьяа байгууллагын үйл
ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх,
үр дүнг үнэлэх журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрхэүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.10 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2013 оны 311, 322 дугаар тогтоол, тус газрын газрын Даргын зөвлөлийн хурлын 2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 8 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү тушаал гарсан ай холбогдуулан Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын "Журам батлах тухай" 2010 оны 144 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

Гурав. Журмыг дагаж хэвшүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /Б.Алтансүх/, Хяналт-шинжилгээний газар /Б.Мөнхтулга/-т тус тус даалгасугай.



113938

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа
холбооны газрын даргын 2014 оны 11 сарын
19. өдрийн 10 дугаар тушаалын хавсралт



**ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ХИЙХ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмыг мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын төрийн захирагааны байгууллагын эрхэлсэн асуудлын хүрээнд харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, дээд газрын тогтоол шийдвэрийн (цаашид "Холбогдох эрхзүйн акт гэх) хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх, дүгнэх ажилд мөрдлөг болгоно.
- 1.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь салбарын хөгжлийн бодлого, үйл ажиллагаа, гүйцэтгэлийг хянан ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж гарган хэрэгжүүлэх, хариуцлагыг тогтолцоог бэхжүүлэх, салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад оршино.
- 1.3 Харьяа байгууллага нь энэхүү журамд нийцуулэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон хяналт-шинжилгээ, үнэлгээний журамтай байж болно.
- 1.4 Энэхүү журам нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуй нэгж, байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам". Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан "Захирагааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ыг удирдлага болгоно.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим, хамрах хүрээ, хугацаа

- 2.1 Хяналт шинжилгээ, үнэлгээ нь харьяа байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын их хурлын тогтоол, Засгийн газрын шийдвэр, дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, үйл ажиллагааг дүгнэх, урамшуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, засч сайжруулахад чиглэнэ.
- 2.2 Хяналт-шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагаа нь хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус, баримт, судалгаанд үндэслэсэн үнэн, зөв, бодитой байх зарчмыг баримтална.
- 2.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж буй этгээд нь хууль дээдлэх, шударга, тэгш байх, нууцыг хадгалах, хариуцлага хүлээх ёс зүй, зарчмыг баримтална.

2.4 Хяналт-шинжилгээг хагас жилд нэг удаа Газрын даргын тушаалаар томилогдсон 7 хүртэлх гишүүнтэй Ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу ажиллаж 1 сарын хугацаанд тайлан, дүгнэлтээ гаргана.

2.4.1 Журмын 2.4 дэх хяналт-шинжилгээг төлөвлөгөөт гэж үзэх бөгөөд гэнэтийн болон тухайлсан, хэсэгчилсэн асуудлаар төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээг тайлангийн хугацаанд гүйцэтгэж болно.

2.5 Ажлын хэсэгт ашиг, сонирхлын зөрчилтэй /ТҮЗ-ын гишүүн, хамаарал бүхий этгээд/ хүнийг томилохыг хориглоно.

2.6 Хяналт-шинжилгээний хүрээнд дараах хяналтын асуудлууд хамаарна. Үүнд:

- 2.6.1 Бодлогын зорилтын хэрэгжилтэд тавих хяналт буюу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан тухайн байгууллагын чиг үүрэгт тусгагдсан арга хэмжээ, Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн биелэлтэд тавих хяналт,
- 2.6.2 Байгууллагын чиг үүргийн хяналт буюу Төсвийн шууд захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт, Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хяналт,
- 2.6.3 Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлтэд тавих хяналт буюу хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилтэд тавих хяналт,
- 2.6.4 Байгууллагын ил тод байдалд тавих хяналт буюу цахим хуудас, түүний бүрдэл, бусад ил тод байдлыг илтгэх үзүүлэлтэд тавих хяналт,
- 2.6.5 Байгууллагын шударга байдалд тавих хяналт /Авилгатай тэмцэх газрын авилгын эрсдлийн үнэлгээ/
- 2.6.6 Төрийн болон байгууллагын өмчийн бүртгэл тооцоо ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт,
- 2.6.7 Архив, албан хэрэг хөтлөлтийг нийтлэг дагаж мөрдөх стандарт, журмын хэрэгжилтэд тавих хяналт,
- 2.6.8 Байгууллагын үйл ажиллагааны үр дүн буюу эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, хэрэглэгчийн санал гомдолд тавих хяналт,
- 2.6.9 Ажилтан албан хаагчдынхаа ур чадвар, мэргэшсэн байдлыг дээшлүүлэх, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт.

Гурав. Харьяа байгууллагуудын эрх, үүрэг

3.1 Харьяа байгууллага нь холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүн болон Төсвийн шууд захирагчтай /Агентлагийн дарга/ байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт, салбарын байгууллагын тухайн жилийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд тайлагнана.

3.2 Харьяа байгууллага нь Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа Мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 5 дугаар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 7 дугаар, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндэсний чиглэлийн биелэлтийг 8 дугаар, Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн тайланг 9 дүгээр, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн тайланг энэхүү журмын 2 дугаар, хавсралтад заасан маягтын дагуу тус тус гаргана.

3.3 Хүн амд хүргэж буй үйлчилгээний хүрээнд жил бүр хэрэглэгчдийн судалгаа гаргаж мэдээллийн сан бүрдүүлнэ.

Дөрөв. Хяналт шинжилгээний ажлын хэсгийн эрх, үүрэг

4.1 Хяналт-шалгалтыг зохион байгуулах үүргийг тус Газрын Хяналт-шинжилгээний газар гүйцэтгэнэ.

4.2 Журмын 2.4 дэх хэсэгт зааснаар Ажлын хэсгийг байгуулж Хяналт-шинжилгээний газрын дарга ахлах бөгөөд бүрэлдэхүүнд нь тус байгууллагын бусад газар, хэлтсээс тухайн байгууллага, асуудлыг хариуцсан холбогдох албан тушаалтууд байна.

4.3 Хяналт-шинжилгээний ажлын хэсэг нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.3.1 Хяналт шалгалт хийхдээ харьяа байгууллагын удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох газар, хэлтсийн ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар, тодруулга гаргуулах,

4.3.2 Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх,

4.3.3 Ажлын удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг МТШХХГ-ын удирдлагуудад танилцуулан Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх,

4.3.4 Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх, цаашид хэрэгжүүлэх, анхаарах асуудлын талаар зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах,

төлөвлөгөө, улсын төсөв болон олон улсын зээл, тусlamжаар хэрэгжиж буй мэдээлэл, харилцаа холбооны төсөл, хөтөлбөрийн тавьсан зорилтод хүргэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-80.0 хүртэл хувь);

- 5.3.4 Тухайн байгууллагад төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, МТШХХГ-ын бодлого, шийдвэр, үүрэг даалгавар, үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, улсын төсөв болон олон улсын зээл, тусlamжаар хэрэгжиж буй мэдээлэл, харилцаа холбооны төсөл, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, санхүүгийн асуудал шийдэгдэж ажил тодорхой хэмжээнд эхэлсэн, санхүүгийн асуудал шийдэгдээгүй ч өөрсдөөс хамаарах асуудлаа шийдвэрдэсэн, дээд шатны байгууллагад асуудлаа өргөн барьсан бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0-60.0 хүртэл хувь);
 - 5.3.5 Тухайн байгууллагад төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, МТШХХГ-ын бодлого, шийдвэр, үүрэг даалгавар, үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, улсын төсөв болон олон улсын зээл, тусlamжаар хэрэгжиж буй мэдээлэл, харилцаа холбооны төсөл, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь);
 - 5.3.6 Тухайн байгууллагад төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, МТШХХГ-ын бодлого, шийдвэр, үүрэг даалгавар, үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, улсын төсөв болон олон улсын зээл, тусlamжаар хэрэгжиж буй мэдээлэл, харилцаа холбооны төсөл, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь);
 - 5.3.7 Тухайн байгууллагад төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, МТШХХГ-ын бодлого, шийдвэр, үүрэг даалгавар, үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, улсын төсөв болон олон улсын зээл, тусlamжаар хэрэгжиж буй мэдээлэл, харилцаа холбооны төсөл, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг "0" гэж үзнэ.
- 5.4 Төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний үр дүнгийн үнэлгээг Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр, дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ын дагуу үнэлж, баталгаажуулсан дүнгээр тооцно.
- 5.5 Энэхүү журмын 3, 4 дүгээр хавсралтын үнэлгээний оноог гаргахдаа үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн түвшин (хувь)-ийг 00,5-аар үржүүлэх ба өрөнхий үнэлгээг гаргахдаа нийт онооны нийлбэрийг үнэлгээний тоонд хуваана.

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлагналт, хариуцлага

- 6.1 Ажлын хэсэг нь хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын тайлан буюу харьяа байгууллагуудад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, илэрсэн дутагдал, зөрчлийг арилгах, засах арга хэмжээний санал, байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээр авсан оноо, дүнгээс хамааруулан тухайн байгууллагын удирдлагыг урамшуулах, эсхүл зохих хариуцлага тооцох үндэслэл, санал зэрэг асуудлыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 6.2 Даргын зөвлөлийн хурлаар хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын тайланг хэлэлцэж, дараах шийдвэрийг гаргана. Үүнд:
 - 6.2.1 Тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгээр "Бүрэн хангальтай" буюу 90-ээс дээш үнэлгээ авсан бол тухайн байгууллагын удирдлагыг 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар урамшуулах, үргэлжлүүлэн гэрээ байгуулж ажиллах
 - 6.2.2 Тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгээр "Хангальтай" буюу 70-90 үнэлгээ авсан байгууллагын удирдлагатай үргэлжлүүлэн гэрээ байгуулж ажиллах,
 - 6.2.3 Тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгээр "Дутагдалтай" буюу 60-70 үнэлгээ авсан бол тухайн байгууллагын удирдлагад ажил сайжруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, үүрэг, чиглэл өгч үргэлжлүүлэн гэрээ байгуулж ажиллах
 - 6.2.4 Тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгээр "Хангальгүй" буюу 60-аас доош үнэлгээ авсан бол тухайн байгууллагын удирдлагыг ажлаас чөлөөлөх саналыг эрх бүхий байгуулгад гаргах.

-----оОо-----